



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/148

Хэрлэн сум

Хонхот бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Чингис хотод 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдах Хонхот бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хавсралт

**2024 ОНД ХЭНТИЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
ХОНХОТ БӨМБӨГИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Цом (том) шилдэг	6	180,000	1,080,000
2	Цом (жижиг) шилдэг	4	100,000	400,000
3	Медал	42	18,000	756,000
4	Өргөмжлөл шилдэг	4	12	48000
5	Шагнал 1-р байр	2	500,000	1,000,000
6	Шагнал 2-р байр	2	300,000	600,000
7	Шагнал 3-р байр	2	200,000	400,000
8	Баннер 4x3	1	20000	240,000
9	Дурсгалын зүйлс	50	10,000	500,000
Бүгд үнэ				5,000,000